



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр


Дугаар 261

Улаанбаатар  
хот

Тавантолгойн цахилгаан станцын  
төслийг эрчимжүүлэх тухай

Олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын өрийн бичгийн эх үүсвэрээр төслийг санхүүжүүлэх Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 28/20 тоот зөвлөмжийг үндэслэн Засгийн газрын өрийн бичгийн эргэн төлөлтийг баталгаажуулах, төрийн хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих 450 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төсөлд төрөөс олгох санхүүжилтийг давуу эрхийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй мезанин зээл хэлбэрээр олгохыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.
2. Хөрвөх давуу эрхийн хувьцаа нь компанийн нийт гаргасан хувьцааны 1/3 (гуравны нэгээс) хэтрэхгүй байхаар тогтоосугай.
3. Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 80 дугаар тогтоолын 1 дэх заалтаар олгохоор шийдвэрлэсэн төслийн санхүүжилтийн эхний ээлжинд шаардагдах 50 сая ам.доллар болон цаашид төрөөс олгох санхүүжилтийг энэхүү тогтоолын 1-д заасан мезанин зээлийн хэлбэрээр төслийн нэгж, төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанид олгох, холбогдох гэрээг байгуулахыг Эрчим хүчний сайд М.Сономпил, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын 1-д заасан зээлийг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлд төрийг төлөөлөн давуу эрхийн хувьцааны өмчлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд М.Сономпилд зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн өмчийн оролцоотой компани байгуулах тухай" Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 129 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Эрчим хүчний сайд

Н.АЛТАНХУЯГ

М.СОНОМПИЛ